



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2020. 08. 18 № 05

Асуулга тавих тухай

Сүүлийн жилүүдэд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа эрчимтэй хөгжсөнөөр Өмнөговь аймаг улсын төсвөөс татаас авдаггүй, бусад аймгуудтай харьцуулахад илүү өндөр хэмжээний татварын орлогыг улсын төсөвт төвлөрүүлдэг стратегийн ач холбогдол бүхий аймаг болсон. Гэвч тус аймагт хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол, усны хомсдол нэмэгдэж, үр дүнд нь иргэд, малчид хохирч, байгаль орчин сүйдсээр өнөөдрийг хүрлээ.

Өвөлжөө, хаваржаа, зуслангийн газар нь уурхайн эдэлбэрийн орчинд орсон иргэд шүүхийн шийдвэрээр газар өмчлөх, эзэмших эрхээ уул уурхайн үйл ажиллагаанд алдаж, нутаглах нутаггүй, малаа бэлчээх бэлчээргүй болж, иргэд болон уул уурхайн компани хоорондын зөрчил маргаан даамжирсаар байна.

Тухайлбал, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Гоёот багийн нутаг дэвсгэрт алт олборлох MV-000114917, MV-00020529, MV-000117452 тоот тусгай зөвшөөрлийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа “АГМ майнинг” ХХК нь 2018, 2019 онуудад Ашигт малтмалын тухай болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулиудыг удаа дараа зөрчсөн нь эрх бүхий байгууллагуудын хяналт шалгалтын дүнгээр тогтоогдсон байна. Улмаар тус компанийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах тухай саналыг холбогдох төрийн байгууллагад хүргүүлсэн боловч хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ өнөөдрийг хүртэл аваагүй байгаа талаар орон нутгийн удирдлага болон иргэд байнга гомдол гаргаж байна.

Иймд Улсын Их Хурлын гишүүн миний бие дээр дурдагдсан асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

2020000040

1. Өмнөговь аймгийн Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж байгаа “АГМ майнинг” ХХК-ийн үйл ажиллагаа Ашигт малтмалын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг зөрчсөн нь холбогдох төрийн байгууллагуудын шалгалтаар тогтоогдсон. Түүнчлэн Өмнөговь аймгийн Засаг даргын 2019 оны А/1277 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг тус компанийг биологийн нөхөн сэргээлт хийгээгүй, шимт хөрсний овоолго үүсгээгүй, газар, газрын хэвлийн эвдрэлийн хэмжээ талбайг тогтоох, нөхөн сэргээлт, гадаргуугийн шинжилгээнд хяналт тавих ажил хийгээгүй, Багийн Иргэдийн Нийтийн Хуралд байгаль орчны ажлын гүйцэтгэлийг нэг ч удаа тайлагнаж байгаагүй гэсэн дүгнэлт гаргаж, түүнийг нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас томилогдсон ажлын хэсэг баталгаажуулсан байхад тус компанийн үйл ажиллагаа яагаад одоо хүртэл хэвийн үргэлжилсээр байна вэ? Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар;


2. 2016-2020 онуудад Өмнөговь аймагт хууль зөрчин үйл ажиллагаа явуулсан хэдэн уул уурхайн компанийн тусгай зөвшөөрлийг цуцалсан, тэдгээр компаниудад ямар хариуцлага тооцсон талаар мэдээлэл ирүүлнэ үү. Тухайлбал, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2019 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 384 дүгээр шийдвэрээр Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж байсан MV-017038, MV019036 тоот тусгай зөвшөөрөл, 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн тушаалаар 8 аж ахуйн нэгжийн 10 тусгай зөвшөөрлийг цуцалсан. Тэдгээр талбайг чөлөөлж, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, орон нутагт хүлээлгэн өгөх ажил ямар түвшинд явж байгаа талаар;

3. Өнөөдрийн байдлаар Өмнөговь аймагт уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшдэг ямар аж ахуйн нэгжүүд байгаа талаар болон тэдгээрээс хэд нь хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа талаар мэдээлэл ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлж, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.БАТ-ЭРДЭНЭ

2020000040